



“ДОРНОД БҮСИЙН ЭРЧИМ ХҮЧНИЙ СИСТЕМ”  
ТӨРИЙН ӨМЧИТ ХУВЬЦААТ КОМПАНИЙН  
ЗАХИРЛЫН ТУШААЛ

2021 оны 01 сарын 18 өдөр

Дугаар 5/08

Хэрлэн сум

Г Цалинтай чөлөө, буцалтгүй тусламж Г  
олгох тухай

Хөдөлмөрийн тухай хуулийн 80 дугаар зүйлийн 80.1, Захиргаа ҮЭ-ийн хорооны 2020 оны Хамтын гэрээний 5.4, 5.5 дахь заалтуудыг тус тус үндэслэн ТУШААХ нь:

1.Механик засварын цехийн аппаратчин ажилтай Чойжоогийн Түвшинбаярын төрсөн эх нь өвчний учир нас барсан тул 2021 оны 01 дүгээр сарын 18 ны өдрөөс ажлын 5 хоногийн хугацаатай цалинтай чөлөө, эрчим хүчний салбарын хөдөлмөрийн хөлсний доод хэмжээг 2 дахин нэмэгдүүлсэнтэй тэнцэх хэмжээний буюу 1,344,000 /Нэг сая гурван зуун дөчин дөрвөн мянга/ төгрөгийн нэг удаагийн буцалтгүй тусламжийг тус тус олгосугай.

2.Ч.Түвшинбаярт буцалтгүй тусламж олгож, чөлөөний хугацааг цагийн балансад тусгаж тооцохыг Механик засварын цех /П.Тогтох/, Санхүү бүртгэлийн хэлтэс /Д.Гэрэлчулуун/-т зөвшөөрсүгэй.

ГҮЙЦЭТГЭХ ЗАХИРАЛ



Г.ОТГОНБААТАР